212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас			281,600,600.0	259,588,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,874,457,500.0	1,854,714,267.0	2,135,435,000.0	1,698,072,447.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	205,000,000.0	205,000,000.0	205,000,000.0	205,000,000.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	205,000,000.0	205,000,000.0	205,000,000.0	205,000,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,669,457,500.0	1,649,714,267.0	1,930,435,000.0	1,493,072,447.0
213203	Нийгмийн заламжийн тэтгэвэр, тэтгэмж	174,500,000.0	174,471,700.0	174,500,000.0	110,505,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	202,504,100.0	191,794,976.0	644,330,600.0	572,752,926.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,013,998,700.0	1,006,846,956.0	840,321,400.0	552,513,954.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,540,900.0	6,540,900.0	0.0	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	271,913,800.0	270,059,735.0	271,283,000.0	257,300,567.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,659,731,900.0	8,963,539,894.0	9,080,681,100.0	7,558,298,424.0
2200	Дотоод эх үүсвэрээр	9,659,731,900.0	8,963,539,894.0	9,080,681,100.0	7,558,298,424.0
220001	Барилга байгууламж			107,761,200.0	105,222,310.0
221001	Их засвар	571,283,000.0	547,588,425.0	605,000,000.0	542,535,268.0
223001	Бусад хөрөнгө	9,088,448,900.0	8,415,951,469.0	8,367,919,900.0	6,910,540,846.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР З	4,360,749,600.0	2,884,559,032.2	3,688,799,400.0	1,818,247,826.0
230001	Эргэж төлөгдөх зээл	4,360,749,600.0	2,884,559,032.2	3,688,799,400.0	1,818,247,826.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	87,259,605,500.0	85,283,632,153.8	105,189,069,600.0	96,754,249,267.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,635,795,400.0	46,635,795,400.0	57,125,914,700.0	54,156,417,614.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	46,635,795,400.0	46,635,795,400.0	57,125,914,700.0	54,156,417,614.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,446,775,100.0	34,410,850,509.5	37,469,622,100.0	39,285,374,608.8
132001	Орон нутгийн төсвөөс	25,766,347,400.0	27,750,351,269.1	31,715,730,900.0	33,978,391,343.8
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	6,680,427,700.0	6,660,499,240.3	5,753,891,200.0	5,306,983,265.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС СА	693,323,000.0	580,033,330.0	693,322,900.0	682,639,931.0
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		66,189.0		0.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	693,323,000.0	579,967,141.0	693,322,900.0	682,639,931.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГА АНААС	7,483,712,000.0	3,656,952,914.3	9,900,209,900.0	2,629,817,113.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,163,038,100.0	2,361,641,328.0	3,277,466,200.0	1,946,805,568.8
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,853,019,000.0	1,295,311,586.3	814,576,200.0	683,011,533.4
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,467,654,900.0	0.0	5,808,167,500.0	11.0
4	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,400,544,560.3		2,035,995,765.2
5	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,035,995,765.2		2,301,264,922.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	165.0	165.0	175.0	170.0
610001	Төсвийн байгууллага	160.0	160.0	166.0	166.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	5.0	5.0	9.0	4.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4,184.0	4,208.0	4,302.0	4,215.5
620001	Удирдах ажилтан	323.0	319.0	327.0	334.0
620002	Гүйцэтгэх ажилтан	2,706.0	2,709.0	2,752.5	2,673.5
620003	Үйлчлэх ажилтан	1,098.0	1,123.0	1,169.5	1,154.0
620004	Гэрээт ажилтан	57.0	57.0	53.0	54.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	32,289.0	30,973.0	32,535.0	29,905.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРТУУЛЬД СУРАЛЦ	22,456.0	21,975.0	22,301.0	21,016.0
630001	Төрийн өмчит ЕБС	22,426.0	21,975.0	22,301.0	21,016.0
630002	Хувийн ЕБС	30.0			0.0
631	СУРТУУЛГИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУ	9,833.0	8,998.0	10,234.0	8,889.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	9,833.0	8,998.0	10,234.0	8,889.0
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.0	6,227.0	0.0	358.0
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсэдийн тоо		1,218.0		358.0
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсэдийн тоо		5,009.0		0.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	4,184.0	4,208.0	4,302.0	4,215.5



**Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	351.0	346.0	346.0	344.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ГТ)	3.0	3.0	3.0	3.0
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ГҮБД)		108.0	38.0	114.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ГҮ)	127.0	129.0	127.0	128.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ГҮЭМ)		23.0	316.0	328.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ГҮ)	3,435.0	3,330.0	3,208.0	3,029.5
650010	Гэрээт ажилтан	96.0	97.0	92.0	94.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	172.0	172.0	172.0	175.0
Баталгаажуулсан:			Б.Эрдэнэцэцэг Ц.Мөнхбаяр		
Ерөнхий нягтлан бодогч			Б.Эрдэнэзул		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Өвөрхангай ТӨЗ				НТ-2
НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН				/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5393092969.67	7,717,426,172.63	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4819049699.67	7,409,052,972.63	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4678920178.94	6,883,818,928.20	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	819329668.84	1,103,362,880.05	
210101	Үндсэн цалин	612831827.14	901,809,941.05	
210102	Нэмэгдэл	66248796.00	29,340,681.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	46011901.00	62,100,000.00	
210104	Урамшуулал	32151061.70	44,018,137.00	
210105	Гэрээт ажлын хөлс	62086083.00	66,094,121.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113780525.87	143,411,552.30	
210201	Тэтгэврийн даатгал	112547691.87	93,623,687.97	
210202	Тэтгэмжийн даатгал	1152001.00	8,148,275.10	
210203	ҮОМШӨ-ний даатгал	25260.00	23,442,954.44	
210204	Ажилгүйдлийн даатгал	5052.00	1,654,238.69	
210205	Эрүүл мэндийн даатгал	50521.00	16,542,396.10	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82753457.00	110,589,213.00	
210301	Гэрэл, цахилгаан	61328379.00	97,711,168.00	
210302	Түлш, халаалт	18105258.00	8,837,270.00	
210303	Цэвэр, бохир ус	3319820.00	4,040,775.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	331124983.75	415,007,563.34	
210401	Бичиг хэрэг	21159684.00	12,372,220.00	
210402	Тээвэр, шатахуун	172090751.00	208,328,396.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3934628.75	4,578,723.34	
210404	Ном, хэвлэл	22274510.00	10,727,810.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19215000.00	15,345,580.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	92450410.00	163,654,834.00	
2105	Нормативт зардал	55027100.00	80,174,565.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	355900.00	59,699,985.00	
210502	Хоол, хүнс	5946250.00	6,799,880.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48724950.00	13,674,700.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	278737414.00	765,383,551.88	
210601	Багаж, техник хэрэгсэл	83411499.00	487,021,064.00	
210602	Тавилга	38794909.00	79,651,500.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1800000.00	11,130,800.00	
210604	Урсгал засвар	154731006.00	187,580,187.88	
2107	Томилголт, зочны зардал	20627800.00	7,504,200.00	
210702	Дотоод албан томилголт	20627800.00	7,504,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1277862671.33	1,859,974,902.21	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1274042200.00	1,858,012,252.21	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	440000.00	394,400.00	



Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	18205.33	477,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	608370.00	46,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	57000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1072800.00	-
210807	Газрын төлбөр	494566.00	821,800.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1129530.00	190,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1699676558.15	2,398,410,500.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1526881261.15	2,356,085,754.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	172795297.00	42,324,746.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140129520.73	525,234,044.43
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	400000.00	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	400000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	45424220.30	201,493,947.43
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4767920.00	12,560,457.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2652865.00	14,428,332.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38003435.30	174,505,158.43
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	94305300.43	323,740,097.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	19895701.00	-
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх	74409599.43	323,726,397.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		13,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	574043270.00	308,373,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	574043270.00	308,373,200.00
223001	Бусад хөрөнгө	36000000.00	143,890,000.00
225001	Биег ба биег бус хөрөнгө худалдан авсан зардал	538043270.00	164,483,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5412010815.67	7,694,326,172.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5412010815.67	7,694,326,172.63
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	28766500.00	11,874,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ	51946415.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилалдаагүй нөөц	1930528075.00	2,364,284,301.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	2644541298.00	4,860,290,394.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	756228527.67	457,877,477.63
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	18917846.00	-
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4182154.00	23,100,000.00
	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23100000.00	0.00

Баталгаажуулсан:



Б.Эрдэнэцэцэг

Ц.Мөнхзаяа

Ерөнхий нягтлан бодогч

Б.Эрдэнэцэцэг

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Аймгийн Засаг дарга А.Ишдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох 4 зөвлөмж өгсөн болно.

Аудитыг 2021.04.08-наас 2021.04.22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.04.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр



төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитор Ц.Мөнхзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2021.04.08-ны өдрийн 01/202 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллагын зорилго, зарчим, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 14.2.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;
- 14.2.7.өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллага, Засгийн газрын тусгай сан, гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслийн тайлан бүхий хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- 14.2.8.хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах;
- 14.2.10.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх
- 14.3.Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна. гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Өвөрхангай аймаг 2020 оныг “Өвөрхангайд үйлдвэрлэв” жил болгон зарласан.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- МУ-ын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх хууль, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн болон, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

ТЕЗ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа хэдий ч НББ-ийн программ хангамж, тайлагнал, төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарын



мэдлэг, ур чадвар, СТСХэлтэс болон байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо хангалтгүй зэрэг дараах дутагдлууд байна. Үүнд:

- Төсөвт байгууллагуудын хэрэглэж байгаа санхүүгийн программ хангамж, сангийн яамны Э-тайлантай төдийлөн уялдахгүй байгаагаас зарим дансны үлдэгдэл, болон ажил гүйлгээнүүд өөр өөр ангилал кодоор тайлагнагдаж байна.
- ТШЗ-ын аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс дүгнэж харахад: Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил дийлэнх хувийг эзэлж байна. Ер нь ямар ч шалгуур, шаардлага харгалзахгүйгээр нягтлан бодогч нарыг томилж ирсэн, тэдгээрийн мэдлэг чадвар, туршлага дутмаг, НББ-ийн программаа бүрэн эзэмшиж чадахгүй, НББ хөтлөх, дансны харьцаа хийх наад захын мэдлэг байхгүй, хууль журам, дүрмээ судалдаггүйтэй холбоотой байна.
- СТСХэлтсээс нягтлан бодогч болон сумдын төрийн сангуудыг нэгдсэн мэдээ, мэдээлэл, чиглэл заавраар тухай бүр хангаагүй, хоорондын ажлын уялдаа холбоо дутмаг байна.
- Сумдын төрийн сангууд болон нягтлан бодогч нарын ажлыг үнэлж дүгнэдэг, сургах, дадлагажуулах тал дээр учир дутагдалтай байна.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн онлайн “Э-тайлан” программ хангамж ашиглаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн алба дотоод аудитын албанаас 2020 онд дараах чиглэлүүдээр аудит хийсэн байна.

Тайлант хугацаанд хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, норм, стандартын биелэлтийг 13 төсөвт байгууллага, Орон нутгийн өмчит ХХК-1, төсөл хөтөлбөр-2 нийт 16 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой 3 үйлдвэрийн газарт засаглалын аудит, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хэрэгжилтэд 162 төсвийн байгууллагад нийцлийн, Хүний нөөцийн нэгдсэн системийн хэрэгжилтэд түүврээр 65 төсвийн байгууллагуудад мэдээлэл технологийн, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 196 байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд тус тус дотоод аудитыг хийж гүйцэтгэжээ.

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар нийт 1826.6 сая төгрөгийн 137 зөрчлийг илрүүлж, зөрчлийг засаж залруулах 305 заалт бүхий тухайн байгууллагад төвлөрүүлэх 153.4 сая төгрөгийн 122 албан шаардлага, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 29.0 сая төгрөг, тухайн байгууллагад төвлөрүүлэх 0.2 сая төгрөг, нийт 29.2 сая төгрөгийн 12 акт тогтоосон. Үүнээс нийт 27.3 сая төгрөг орон нутгийн төсөвт, тухайн байгууллагад 0.2 сая төгрөгийн актын төлбөр, 126.1 сая төгрөгийн албан шаардлагын төлбөр нийт 126.3 сая төгрөг тухайн байгууллагад төвлөрч, 1.7 сая төгрөг 1 акт шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

Актын биелэлт 94.3 хувьтай, албан шаардлагын биелэлт 99.8 хувьтай байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын 292877.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2928.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Гүйцэтгэлийн үе шатанд тайланд залруулга, болон устгах бичилт хийгдсэнтэй холбоотой материаллаг байдлыг дахин тодорхойлж **1748.9** сая төгрөгөөр тооцлоо.



3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Бичилт
Касст байгаа бэлэн мөнгө	31.0	38.6	7.6
Төрийн сангийн харилцах	7093.6	9018.9	1925.2
Арилжааны банкин дахь харилцах	3441.0	2641.7	-799.3
Хадгаламж			
Дүн	10565.7	11699.2	1133.5

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 10565.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11699.2 сая төгрөг болж, 1133.5 сая төгрөгөөр өссөн байна.

Нэгтгэсэн тайлангаарх мөнгөн хөрөнгө нь дараах байгууллагуудад үлдэгдлээр байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		Арилжааны банкны үлдэгдэл		Кассын үлдэгдэл	
ОНЕОрлого	4,748.7	Төсөвт байгууллага	1.52	Төрийн өмчит ААНБ	38.6
ОНХСан	1,065.5	ТӨААН	2,598.4	Төсөвт байгууллага	0.0
СХСан	951.2	ТББ	1.4		
ЭХСан	242.6	Өрхийн эмнэлэг	40.4		
Техник хяналт барьцаа	1,628.4				
Нэмэлт санхүүжилт	370.3				
Ахмадын сан	12.1				
	9,018.87		2,641.70		38.61

Аудитын илрүүлэлт: Аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 530.6 сая төгрөгийн доорх зөрчлүүд илэрсэн.

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар зарцуулсан, ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 209.5 сая төгрөг /Тухайлбал: ӨВ-Эко мийт ОНӨААН мах худалдан авалтад 2020.01.24-нд 58.0 сая төгрөг, 2020.11.11-нд 4.4 сая төгрөг, 2020.12 сард 73.5 сая төгрөг, гэрэл цахилгааны зардалд 2020.03.31-нд 0.8 сая төгрөг, 2020.06.04-нд 0.9 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн боловч үндсэн баримт байхгүй, касст 10.6 сая төгрөгийн орлого орсон боловч ямар эх үүсвэрээс орсон эсэх нь тодорхойгүй, үндсэн баримт байхгүй, Баянтээг ХК нь худалдан авалт хийхдээ 16.9 сая төгрөгийг анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, Арвайхээр нийтийн тээвэр гэрэлтүүлэг ТҮК нь Хятадаас мөнгөн гуйвуулгаар 26.1 сая төгрөгийн материал татан авсан боловч эд хариуцагчийн тайлангаар орлого аваагүй, 2.1 сая төгрөгийн зарцуулалтын үндсэн баримт байхгүй, Хайрхандулаан сумын ЭМТөө 4.2 сая, Баруунбаян-Улаан сумын ЭМТөө 1.0 сая, Нарийнтээл сумын ЗДТГазар 9.2 сая, Өлзийт сумын ЕБС 2.6 сая, Уянга сумын ИТХ 2.8 сая төгрөгийг бүрдүүлбэр дутуу баримтаар зарцуулсан байна./

Мөнгөн хөрөнгийн хяналт хангалтгүй, Хөрөнгийн тооллогын бүртгэл хангалтгүй 7.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Арвайхээр цэцэрлэгжилт 5.5 сая, ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ 0.2 сая, Баянгол сумын ИТХ 1.4 сая /

- Цалин урамшуулал, ХХОАТ, НДШ илүү дутуу олгосон 0.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.



• Мөнгөн гүйлгээний тайлагнал, бэлэн мөнгөний тайлан гаргалттай холбоотой **311.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.** /Нарийнтээл сумын ЗДТГазар 78.0 сая, ӨВ-ЭКО мийт 214.1 сая, Нарны дөш ӨЭМТөв 14.8 сая, Нарийнтээл ЭМТөв 3.4 сая, Баянгол сумын ЭМТөв 1.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн/

ТЕЗ-ийн нэгдсэн тайлангаар Сангийн яамнаас ирүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн тулгалтаар Баянтээг ХК нь **1.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээ авлагаар бүртгэсэн байна.**

3.5.2 Авлага

Авлага өмнөх оноос 944.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас санхүүжилтийн авлага	10.0	57.6	47.6
Ажилчидтай холбогдсон авлага	58.0	66.2	8.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	3.8	7.8	4.1
Дансны авлага	783.4	1235.5	452.0
Зээлийн хүүгийн авлага	175.7	179.4	3.7
Татвар шимтгэлийн авлага	51.8	30.6	-21.2
Бусад авлага	6692.5	6959.7	267.1
Зээлийн авлага	0	182.5	182.5
Дүн	7775.4	8719.4	944.0

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хувь хүмүүсээс авах 6545.0 сая төгрөгийн авлага нь 19 сумын ОНХСан, эрсдэлээс хамгаалах сан, сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, малжуулах төсөл болон өвс тэжээлийн авлага байна.

Байгууллагаас авах нийт авлагын 25.1 хувь буюу 150.0 сая төгрөгийг Арвайхээр сумын ЗДТГ-ын нөөцийн махны авлага, 24.7 хувь буюу 148.0 сая төгрөгийг Онги ус суваг ОНӨААТҮГ-ын ажил үйлчилгээ үзүүлсэн төлбөртэй үйлчилгээний болон борлуулалтын авлага, 26.6 хувь буюу 179.4 сая төгрөг нь Төгрөг, Хужирт, Уянга, Тарагт, Өлзийт, Есөнзүйл, Баянгол, Бат-өлзий, Баян-өндөр сумдын ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмжийн авлага байна.

Баянтээг ХК, Өв эко мийт ХХК-иудын борлуулалтын болон татвар,ндш-ийн авлага 1266.1 сая төгрөг байна.

Сумдын эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн даатгалын сангаас хуваарилсан 57.6 сая төгрөг нь төрийн сангийн гүйлгээ хаагдсанаас хойш орж ирсэнээс буцаан татуулсантай холбоотойгоор татаас санхүүжилтийн авлага нэмэгдсэн болно.

Авлагын данстай холбоотой **410.6 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна.**

- Авлага бүртгэгдсэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, хаанаас авлагатай болохыг тодруулга тайланд тодруулаагүй **116.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.** /ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ-т 101.9 сая, Хархорин сумын 2-р сургуульд 8.6 сая төгрөг, Төгрөг сумын ЗДТГ-т 1.7 сая төгрөг, Бүрд сумын ЭМТөвд 3.0 сая төгрөг, Өлзийт сумын соёлын төвд 0.7 сая төгрөгийн зөрчил тус тус илэрчээ./
- СХСангийн зээлийн анхан шатны баримтын бүрдэл, зээлдүүлэгчийн хяналт сул байсантай, цаашид найдваргүй, эрсдэлтэй зээл бий болохтой холбоотой **210.6**



сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Зүүнбаян-Улаан сумын СХСанд 2.1 сая төгрөг, Бүрд сумын СХСанд 41.0 сая төгрөг, Баруунбаян-Улаан сумын СХСанд 73.0 сая төгрөг, Баян-Өндөр сумын СХСанд 94.5 сая төгрөгийн зээлийн авлага байна./

- Авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нийт **70.5** сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Сант сумын СХСанд 17.7 сая төгрөг, Хужирт сумын 1-р сургуульд 2.9 сая төгрөг, Тарагт сумын ЕБС-д 8.6 сая төгрөг, Туяа багийн сургуульд 9.2 сая төгрөг, Уянга сумын 1-р сургуульд 8.6 сая төгрөг гэх мэт.../
- Хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэлгүй харилцагч байгууллагад илүү шилжүүлж авлагаар бүртгэсэн **13.4** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Уянга сумын ЗДТГазар 6.3 сая төгрөг, 1-р сургууль 4.7 сая төгрөг, Гучин-Ус сумын СӨБ 1.8 сая төгрөг, Баруунбаян-Улаан сумын ИТХ 0.5 сая төгрөг байна./

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс тайлант онд 38.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Урьдчилгааны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	143.6	104.5	-39.1
Цалингийн урьдчилгаа	0.2	0.9	0.7
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Дүн	143.8	105.4	-38.4

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих ажлын урьдчилгаа болон боловсролын байгууллагуудын техник хэрэгслийн үнийг урьдчилж шилжүүлснийг бүртгэсэн байна.

Арвайхээр сумын 4-р сургууль бэлтгэн нийлүүлэгчид тоног төхөөрөмжийн үнэнд **9.7** сая төгрөгийг урьдчилан шилжүүлж хөрөнгөнд хий орлого авсан байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 34260.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1331.8	1513.6	181.8
Дуусаагүй үйлдвэрлэл	0	10880.6	10880.6
Бэлэн бүтээгдэхүүн	200.1	293.0	92.9
Хангамжийн материал	4380.4	5544.2	1163.7
Биологийн хөрөнгө	0	21.6	21.6
Мал амьтад	159.4	174.4	15.0
Нөөц /тэжээлийн нөөц, бусад эргэлтийн хөрөнгө/	812.2	22716.7	21904.5
Дүн	6884.0	41144.1	34260.2

Тайлант онд бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн гол шалтгаан нь Улсын болон



орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж, тухайн ондоо дуусаагүй, 2021 онд ашиглалтад орох 10880.6 сая төгрөгийн барилга байгууламжуудыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн.

Нөөцийн барааны үлдэгдэл /Бусад эргэлтийн хөрөнгө/ 21904.5 сая төгрөг нэмэгдсэн нь 2011 оноос хойш Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Хужирт, Баянгол сумдад хэрэгжүүлж буй цэвэрлэх байгууламж барих ажлын санхүүжилтийг урт хугацаат зээлийг өглөгөөр бүртгээгүй байсныг холбогдох шийдвэр, хоорондын тооцоог үндэслэн бүртгэсэнтэй холбоотой хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд хангамжийн материал дансны үлдэгдэл 1163.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 14-р цэцэрлэг шинээр ашиглалтад орсон, 5 дугаар сургууль болон бусад цэцэрлэг сургуулиудад үнэ төлбөргүй бараа материал /БСУГ-аас сургуулиудад ирсэн кабинет/ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данстай холбоотой 22920.0 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн.

-Бараа материалын тайлангийн орлого зарлагын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, шаардах хуудас, замын хуудас зэргийг хөтлөөгүй, гарын үсгийн бүрдэл дутуу зэрэг 89.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ТҮК-д 71.8 сая төгрөгийн аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, засварын материал, шатахууны 57.3 сая төгрөгийн орлогын баримт, 61.1 сая төгрөгийн зарлагын үндсэн баримт дутуу, ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ-т 5.3 сая төгрөг, Есөнзүйл сумын цэцэрлэгт 8.8 сая төгрөг, аймгийн ЗДТГ-т 3.9 сая төгрөг /

-Бараа материалын тооллогыг хуулийн дагуу хийгээгүй, дутуу, чанаргүй хийсэнтэй холбоотой 177.8 сая төгрөгийн зөрчил дараах байгууллагуудад илэрсэн./Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ТҮК-д 1.7 сая төгрөг, Энэрэл хархорин өрхийн эмнэлэгт 3.4 сая төгрөг, Хужирт сумын ЭМТөвд 5.2 сая төгрөг, Нарийнтээл сумын ЗДТГ-т 6.8 сая төгрөг, Соёлын төвд 1.1 сая төгрөг, Есөнзүйл сумын цэцэрлэгт 1.0 сая төгрөг, Арвайхээр сумын 7-р цэцэрлэгт 1.9 сая төгрөг, Гэр бүл хүний хөгжлийн төвд 156.7 сая төгрөг /

-Бараа материалыг буруу ангилалд бүртгэсэн, бараа материалын тайлан гаргаагүй, шууд зардалд бичилт хийсэн зэрэг нийт 355.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Онги-Ус суваг ОНӨААТҮГ 154.3 сая төгрөгийн бараа материалыг буруу ангилалд бүртгэсэн, ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ 162.9 сая төгрөгийн бараа материалд эд хариуцагчийн тайлан гаргаагүй, Түшиг дөлгөөн ӨЭМТөв 26.5 сая төгрөгийн бараа материалд тайлан гаргаагүй, Хархорин сумын өрхийн эмнэлэгт 1.5 сая төгрөг, Зүүнбаян-Улаан сумын ИТХ-д 3.5 сая төгрөг, Сант сумын ЗДТГазарт 1.1 сая төгрөг, Арвайхээр сумын ЗДТГазарт 3.0 сая төгрөг, 2-р сургуульд 1.8 сая төгрөг, 7-р цэцэрлэгт 0.8 сая төгрөг гэх мэт/

-Өлзийт сумын ЗДТГазарт 1.6 сая төгрөгийг шатахууны үнэнд шилжүүлээд бараагаа аваагүй байж авлагаар бус материалын үлдэгдлээр тайлагнасан байна.

-ТЕЗ-ийн тайланд Дамжуулан зээлдүүлэхийн 22295.4 сая төгрөгийн өр төлбөрийг тайланд тусгахдаа өмнөх үеийн үр дүнд хаасныг бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэж залруулсан

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө 15095.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	245631.1	258834.6	13203.5
Биет бус хөрөнгө	10595.4	12487.7	1892.2



Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Газар	0.8	0.8	0
Дүн	256227.2	271323.0	15095.8

Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2779.4 сая төгрөг, үнэ төлбөргүй болон шилжүүлэн авсан 47762.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 18440.8 сая төгрөгийн дуусаагүй барилга дансны үлдэгдлийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд шилжүүлсэн, 3202.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, тайлант хугацаанд 13802.3 сая төгрөгийн элэгдэл тооцож зардалд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой **23764.0** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн.

-Үндсэн хөрөнгийн бүртгэл, тодруулга тайлангийн уялдаа, хөрөнгийн тайлагналтай холбоотой **19420.2** сая төгрөгийн зөрчил илэрсэн. /ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ-т 1201.7 сая төгрөг, Хархорин сумын 3-р цэцэрлэгт 214.7 сая төгрөг, Баянгол сумын ЕБС-д 17830.3 сая төгрөг, Хайрхандулаан сумын соёлын төвд 39.0 сая төгрөг, Есөнзүйл сумын ЕБС-д 20.3 сая төгрөг, Уянга сумын 1-р цэцэрлэгт 9.3 сая төгрөг, ГБХХТөвд 100.0 сая төгрөг, Хөгжимт драмын театрт 1.7 сая төгрөг, ТЕЗ-ийн санхүүгийн тайланд 3.2 сая төгрөг /

- Үндсэн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийгээгүй, дутуу, чанаргүй хийсэнтэй холбоотой **3647.1** сая төгрөгийн зөрчил илэрсэн. /ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ-т 3323.5 сая төгрөг, Хайрхандулаан сумын ЕБС-д 20.6 сая төгрөг, Нарийнтээл сумын ЗДТГазарт 264.5 сая төгрөг, Соёлын төв 28.8 сая төгрөг, Арвайхээр сумын 4-р сургууль 9.7 сая төгрөг /

-Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч данс бүртгэлээс хасаагүй, дахин үнэлгээ хийгдээгүй, ашиглагдаж байгаа нийт **353.4** сая төгрөгийн зөрчил илэрсэн./Арвайхээр ТҮК ОНӨААТҮГ-т 317.2 сая төгрөг, Нарны дөш өрхийн эмнэлэгт 34.2 сая төгрөг, Богд сумын соёлын төвд 0.9 сая төгрөг, Эрдэнэ зуу музейд 0.5 сая төгрөг, Хархорин сумын 2-р сургуульд 0.6 сая төгрөг /

-Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй **219.1** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

/Бат-Өлзий сумын төрийн сан 24.0 сая төгрөг, Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ТҮК 44.6 сая төгрөг, Онги-Ус суваг ОНӨААТҮГ 71.2 сая төгрөг, Арвайхээр цэцэрлэгжилт ТҮК 0.6 сая төгрөг, ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ 19.9 сая төгрөг, Хайрхандулаан ЕБС 1.6 сая төгрөг, Нарийнтээл ЕБС 1.1 сая төгрөг, Баян-Өндөр ЕБС 55.9 сая төгрөг /

-Үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү дутуу тооцсонтой холбоотой **102.3** сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ТҮК 98.7 сая төгрөг, Гэр бүл хүүхэд залуучуудын төв 3.6 сая төгрөг /

-Үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн **21.8** сая төгрөгийн зөрчил илэрсэн./Бүрд сумын ЕБС 20.0 сая төгрөг, Усан спорт сургалтын төв 1.4 сая төгрөг, Хужирт сумын төрийн сан 0.4 сая төгрөг /

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3788.1 сая, эцсийн үлдэгдэл 24922.2 сая төгрөг болж, 21134.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	732.1		-732074.6
Ажилчидтай холбоотой өглөг	40.4	38.6	-1813.0



Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бараа үйлчилгээний зардлын өглөг	55.1	37.0	-18.1
Татаас санхүүжилтийн өглөг	562.5	602.1	39.6
Бусад өглөг	1626.5	1177.5	-449.0
Урьдчилж орсон орлого	0	0.1	0.1
Богино хугацаат өр төлбөр дүн	3016.7	1855.4	-1161.3
Төрийн өмчит ААН-ийн зээл	0	771.4	771.4
Олон улсын санхүүгийн байгууллагаас	0	22295.4	22295.4
Бусад урт хугацаат өр	771.4	0	-771.4
Урт хугацаат өр төлбөр дүн	771.4	23066.8	22295.4
Нийт өр төлбөрийн дүн	3788.1	24922.2	21134.1

Эх сурвалж: Аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр 1161.3 сая төгрөгөөр буурсан нь “Баянтээг ХК” жижиг хувьцаа эзэмшигчдэдээ нийт 46.5 сая төгрөгийн ноогдол ашиг олгохоор тооцож өглөг үүсгэсэн байна. Мөн техник тоног төхөөрөмжийн өр төлбөрийг төлж барагдуулсанаар дансны өглөг 975.3 сая төгрөгөөр буурсан байна.

Байгууллагад төлөх 674.4 сая төгрөгийн өглөгийн 245.0 сая төгрөгийг Өв.Эко мийт ХХК-ны Баянтээг ХК-ээс авсан зээлийн өглөг, 130.0 сая төгрөг нь зээлээр авсан тоног төхөөрөмж, 100.0 сая төгрөг нь Арвайхээр сумын ЗДТГ-т төлөх нөөцийн махны өглөгүүд зээлж байна.

Сумдын эрүүл мэндийн төвүүдийн эмийн зардлын өглөг 178.3 сая төгрөг, Уянга сумын ОНХСангийн хөрөнгөөр он дамжин хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдэд олгох 21.1 сая төгрөгийн санхүүжилтийн гэх мэт өглөг байна.

Урт хугацаат өр төлбөр 22295.4 сая төгрөгөөр өссөн.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хот байгуулалтын салбар МОН-2301 төсөл”, Зүүн өмнөд говийн хот байгуулалт хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл”-ийн хүрээнд 2011 оноос хойш Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорин, Хужирт, Баянгол сумдад хэрэгжүүлж буй цэвэрлэх байгууламж барих ажлын санхүүжилтийг урт хугацаат зээлийн өглөгөөр бүртгээгүй байсаныг холбогдох шийдвэр, хоорондын тооцоог үндэслэн 22295.4 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өрийг нэмж бүртгэсэнтэй холбоотой өглөг юм.

Дээрх ажлууд нь Сангийн яам, Өвөрхангай аймгийн Засаг даргын тамгын газар харилцан тохиролцож “ Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-үндэслэн байгуулсан гэрээний хүрээнд хийгдсэн, хэрэгжсэн ажлууд болно.

Өр төлбөр данстай холбоотой 2622.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

-Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй **629.6** сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Онги-Ус суваг ОНӨААТҮГ 20.0 сая төгрөг, ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ 590.3 сая төгрөг, Өлзийт сумын ЕБС 19.2 сая төгрөг /

-Баянтээг ХК-д **220.0** сая төгрөгийн насжилт өндөртэй өр төлбөр байна.

-Өр төлбөрийг тайлан бүртгэлд тусгаагүй нийт **946.5** сая төгрөгийн зөрчил илэрсэн./ТЭЗ-ийн тайланд 908.2 сая төгрөг, Нийтийн тээвэр гэрэлтүүлэг ТҮК-д 0.2 сая төгрөг, Хархорин Ус суваг ОНӨААТҮГ-т 0.8 сая төгрөг, Хархорин сумын 1-р сургуульд 8.6 сая төгрөг, Хужирт сумын 2-р цэцэрлэгт 0.9 сая төгрөг, Төгрөг сумын ИТХ-д 0.2 сая төгрөг, ББУлаан сумын ЗДТГ-т 5.0 сая төгрөг, Нарийнтээл сумын ЗДТГ-т 20.4 сая төгрөг, Соёлын төвд 0.3 сая төгрөг, ЭМТөвд 1.0 сая төгрөг, Есөнзүйл сумын цэцэрлэгт 0.7 сая төгрөг /



Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

-ТЭЗ-ийн санхүүгийн тайланд үйл ажиллагаагы орлого болон нэмэлт санхүүжилтийн орлогыг бүртгэл тайланд буруу ангилан бүртгэсэн тэй холбоотой **923.3** сая төгрөгийн алдаа илэрсэн.

3.5.9 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **4429.1** сая төгрөгийн зөрчил илэрсэн.

-Урсгал үйл ажиллагааны зардлыг илүү дутуу тайлагнасан нийт **3057.5** сая төгрөгийн зөрчил илэрсэн. /ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ-т 775.4 сая төгрөг, Аймгийн ОНХСанд 188.2 сая төгрөг, Бүрд сумын цэцэрлэгт 164.1 сая төгрөг, Өлзийт сумын соёлын төвд 142.1 сая төгрөг, Богд сумын соёлын төвд 1723.5 сая төгрөг, Баян-Өндөр сумын ЗДТГ-т 9.0 сая төгрөг гэх мэт.../

-Батлагдсан зардлыг зориулалт бус зарцуулсан нийт **190.7** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан 43.4 сая төгрөг /Тухайлбал: Аймгийн ЗДТГазарт 9.1 сая төгрөг, Уянга сумын ЗДТГазарт 4.8 сая төгрөг, Баянгол сумын ЭМТөвд 2.3 сая төгрөг, Төгрөг сумын ИТХ-д 7.6 сая төгрөг, Нарийнтээл сумын ИТХ-д 4.3 сая төгрөг гэх мэт..../
- Урсгал үйл ажиллагааны зардлаас хөрөнгө бэлтгэсэн 49.3 сая төгрөг /Тухайлбал: Хархорин, Гучин-Ус, Төгрөг, Бүрд, Арвайхээр, Баянгол сумдын СХСангууд 37.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан, Хужирт сумын ИТХ-д 3.2 сая төгрөг, Нарны дөш өрхийн эмнэлэгт 3.8 сая төгрөг, Гучин-Ус сумын ЭМТөвд 2.2 сая төгрөг гэх мэд/
- Цалингийн зардлаас 55.7 сая төгрөгийг ажилтнуудад түлшний хөнгөлөлт олгосон /Тухайлбал: Хархорин сумын 1-р сургууль 16.8 сая төгрөг, Хужирт сумын ЕБС 16.3 сая төгрөг, Төгрөг сумын ЕБС 5.3 сая төгрөг, Арвайхээр сумын 9-р цэцэрлэг 5.5 сая төгрөг.... гэх мэт/
- Төсөвт зардлуудын хэмнэлт 42.3 сая төгрөгийг "Ахмадын сан" дансанд байршуулж холбогдох хууль журмыг зөрчсөн./Тухайлбал: Баруунбаян-Улаан сумын ЕБС 5.0 сая төгрөг, Уянга сумын 2-р сургууль 13.5 сая төгрөг, 1-р сургууль 8.2 сая төгрөг, Мэргэд сургууль 7.4 сая төгрөг, Бүрд сумын ЕБС 2.0 сая, 4-р цэцэрлэг 1.0 сая төгрөг.... гэх мэт/

-Ажилчдад ЗГ-ын тогтоол болон холбогдох журам зааврыг зөрчин **37.2** сая төгрөгийн цалин нэмэгдэл илүү цагийн хөлс олгосон зөрчил илэрсэн./Тухайлбал: Сант сумын ЗДТГ 3.6 сая төгрөг, ИТХурал 3.6 сая төгрөг, Тарагт сумын ЗДТГазар 3.8 сая төгрөг, Есөнзүйл сумын цэцэрлэг 7.9 сая төгрөг, Уянга сумын 1-р сургууль 7.3 сая төгрөг, 2-р цэцэрлэг 2.5 сая төгрөг, Арвайхээр сумын 2-р сургууль 1.8 сая төгрөг..... гэх мэт/

-Цар тахалтай холбоотой сургууль цэцэрлэг үйл ажиллагаа явуулаагүй байхад хүнсний материал нөөцөлсөн, зардал хэтрүүлсэн **78.8** сая төгрөгийн зөрчил илэрсэн./ Хужирт сумын ЕБС 15.7 сая төгрөг, Хайрхандулаан сумын ЕБС 6.9 сая төгрөг, Есөнзүйл сумын ЕБС 3.3 сая төгрөг, Цэцэрлэг 13.9 сая төгрөг, Арвайхээр сумын 5-р цэцэрлэг 6.2 сая төгрөг, 13-р цэцэрлэг 2.1 сая төгрөг, Нарийнтээл сумын ЕБС 0.2 сая төгрөг, Аймгийн ЗДТГ 30.5 сая төгрөг ... гэх мэт/

-ТЭЗ-ийн нэгтгэсэн тайланд зардлыг буруу ангилалд бүртгэсэн **1064.8** сая төгрөгийн алдаа илэрсэн.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэл



стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 156 мэдээллийг бүрэн оруулсан байна. 3 мэдээлэл хугацаа болоогүй байна.

Орон нутгийн байгууллагуудад шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой **8525.8** сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрсэн.

-Шилэн дансны тухай хуулийн 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;-ээр" мэдээлэх заалтыг зөрчсөн 51 байгууллагын 415 удаагийн 7247.2 сая төгрөгийн орлого зарлагын гүйлгээг шилэн дансны сайтад мэдээлээгүй зөрчил илэрсэн байна.

-Мөн хуулийн 6.4.8. "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;"-ийг сайтад мэдээлнэ заалтыг зөрчин 32 байгууллагад 1278.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан шийдвэрийг мэдээлээгүй зөрчил илэрсэн.

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 40.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	4	40.8	4	40.8			
Нийт дүн	4	40.8	4	40.8			

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 169 төсвийн байгууллага, 9 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 40 тусгай сан, 19 төрийн сан, 1 төрийн бус байгууллага, 11 данс нийт 249 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 183 байгууллага аудитад хамрагдсан, 54 байгууллагад итгэл үзүүлсэн, 1 төрийн бус байгууллагыг аудитад хамруулаагүй, 11 дансны ажил гүйлгээг төсвийн гүйцэтгэлийн аудитад хамруулж үзсэн.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 70 байгууллагыг түүвэрт хамруулж, 113 байгууллагад дүгнэлт хүргүүлээ. Үүнд: "Зөрчилгүй" 100, "Хязгаарлалттай" 12 / Уянга сумын ЗДТГазар, 1 дүгээр сургууль, 2 дугаар сургууль, Хужирт сумын ЕБС, Соёлын төв, Нарийнтээл сумын ЗДТГазар, ИТХ, Хайрхандулаан сумын ЕБС, Арвайхээр сумын 9-р цэцэрлэг, Зүүнбаян-Улаан сумын ИТХ, Хархорин сумын өрхийн эмнэлэг, Арвайхээр гэрэлтүүлэг нийтийн тээвэр ОНӨААТҮГ/, "Сөрөг" 1 /ӨВ-ЭКО мийт ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн байна.



Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өвөрхангай аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн тайлан болон нэгтгэгдсэн харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **137994.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс **122846.0** сая төгрөгийн алдааг залруулж, **51.0** сая төгрөгийн зөрчилд 15 төлбөрийн акт тогтоож, **14563.0** сая төгрөгийн зөрчилд 110 албан шаардлага, **534.0** сая төгрөгийн зөрчилд 44 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд **99381.7** сая төгрөгийн алдааг залруулсан.

- Санхүүгийн байдлын тайланд 24033.1 сая төгрөгийг дараах алдаатай тайлагнасан байна. Үүнд:

№	Дансны нэр	залруулсан дүн	Тайлбар
Санхүүгийн байдлын тайлангийн залруулга			
1	Мөнгөн хөрөнгө	1,833,267.00	Сангийн яамнаас ирүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн тулгалтаар Баянтээг ХК-ийн авлага буурч мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэн.
	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	22,295,363,665.10	Дамжуулан зээлдүүлэхийн өр төлбөрийг өмнөх үеийн үр дүнд хаасныг бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэж залруулсан
2	Биет бус хөрөнгө	3,187,499.84	Аудитлагдсан санхүүгийн тайлан, Сангийн яамны Э-тайлангийн үлдэгдэл зөрүүтэй байсан тул Баянтээг ХК, ИТХ, Номын сангийн бусад үндсэн хөрөнгийг биет бус хөрөнгөд шилжүүлсэн.
3	Бусад өглөг	53,071,705.00	Аудитлагдсан санхүүгийн тайлан нь Сангийн яамны Э-тайлантай зөрүүтэй байна. Бараа үйлчилгээний өглөгийг байгууллагад төлөх өглөг, татварын өглөг, ноогдол ашгийн өглөг, дансны өглөгөд залруулсан.
4	Урт хугацаан өглөг	908,233,566.94	Сангийн яамны тооцоо нийлсэн актаар өглөг нэмэгдсэн
5	Гадаад валютын өглөг	771,440,900.00	Өмнөх оны үлдэгдлийг Э-тайланд буруу шивэгдсэн учраас аудитлагдсан тайлангаар үлдэгдлийг залруулсан
ДҮН		24,033,130,603.88	

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 75348.6 сая төгрөгийн орлого зардалтай холбоотой дараах алдаануудыг залруулсан.

Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлого	268,651,651.73	Төрийн сангууд төвлөрүүлсэн орлого, зардлыг тайлангаасаа хассан учраас залруулж нэмж бүртгэсэн / Бат-Өлзий 5855353.2, Гучин-Ус1986990, Өлзийт-2212050, ЗБУ-5193710, Хайрхандулаан-3299650, Нарийнтээл-3094229, Төгрөг-2298610, Хужирт-4209150
		39,920,452.56	Уянга сумын Төрийн сан Э-тайланд өмнөх оны үлдэгдлээс олгосон эргэн төлөгдөх зээлийг үндсэн үйл ажиллагааны орлогод шивсэн байсныг залруулсан
		560,811,203.00	Баянтээг ХК -ий аудитлагдсан тайлан элэгдлийн зардлыг борлуулалтын өртгөөр бүртгэсэн учраас Э-тайланд залруулсан
2	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого	73,360,448,316.75	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлогыг үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-Үндсэн хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-Бараа материал гэж салгаж залруулсан
3	Нэмэлт санхүүжилтын орлого	43,910,200.00	Аудитлагдсан тайлан ба Э-тайлангийн кодын зөрүүг залруулсан
Дүн		74,273,741,824.04	
4	Эмийн зардал	28,613,759.10	Авлагаар тооцсон ЭМД санхүүжилтийг төвлөрүүлэх шилжүүлгээр бүртгэсэн байсаныг эмийн зардалд залруулсан
5	Хоолны зардал	1,018,751,512.26	ЕБС-ийн хэмнэлт дансны тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг хоолны зардалд тусгасан байсныг ТЗШ төвлөрүүлэх шилжүүлгээр залруулсан
6	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	10,000,000.00	УТХОруулалт дээр тооцоо нийлэхэд нэмж авсан
	Ажил олгогчоос төлөх ндш-н зардлыг буруу ангилалд тайлагнасан.	17,488,208.05	Баянтээг ХК -ий аудитлагдсан тайланд НДШ-ийн зардлыг ашиглалтын зардалд бүртгэсэн байсныг Э-тайлан болон аудитлагдсан тайлангаар залруулсан
Дүн		1,074,853,479.41	
ДҮН		75,348,595,303.45	

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмж

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангаар ажлын уялдаа холбоог сайжруулах, системийн хэмжээнд ажлаа үнэлж дүгнэх, сургах дадлагажуулах,, заавар



зөвлөмж өгөх үйл ажиллагааг сайжруулах талаар 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Харьяа 19 сумын төрийн санг хамруулж, “Зөрчилгүй” 19 дүгнэлт өгсөн. Аудитаар нийт **62.0** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 38.0 сая төгрөгийн алдааг залруулж, 24.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 169 байгууллагаас 35 байгууллагад итгэл үзүүлж, 49 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 74, Хязгаарлалттай 11 / Уянга сумын ЗДТГазар, 1 дүгээр сургууль, 2 дугаар сургууль, Хужирт сумын ЕБС, Соёлын төв, Нарийнтээл сумын ЗДТГазар, ИТХ, Хайрхандулаан сумын ЕБС, Арвайхээр сумын 9-р цэцэрлэг, Зүүнбаян-Улаан сумын ИТХ, Хархорин сумын өрхийн эмнэлэг/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт **28438.2** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 20908.0 сая төгрөгийн алдааг залруулж, 48.8 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 7438.4 сая төгрөгийн зөрчилд 89 албан шаардлага, 43.0 сая төгрөгийн зөрчилд 22 зөвлөмж өгчээ.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 9 аж ахуйн нэгж байгууллагыг аудитад хамруулж бие даасан дүгнэлт гаргасан. “Зөрчилгүй” 7, “Хязгаарлалттай” 1, / Гэрэлтүүлэг нийтийн тээвэр ОНӨААТҮГ / “Сөрөг” 1 /ӨВ-ЭКО мийт ОНӨААН/ дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт **8623.2** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2495.9 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5802.1 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 322.7 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгчээ.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 40 тусгай сангаас 19 санд итгэл үзүүлж, 21 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Аудитаар нийт **1488.6** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 22.3 сая төгрөгийн алдааг залруулж, 1298.3 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 168.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 11 зөвлөмж өгчээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

